\*Холбоо барих зохиогч: [mainjargalg@mas.ac.mn](mailto:mainjargalg@mas.ac.mn), <https://orcid.org/0000-0002-8774-0268>

**Хураангуй.** Монгол идлэг шонхрын популяцийн цөм нутаг болно. Идлэг шонхор манайд Алтайгаас Их Хянганы баруун хэсэг хүртэлх нутагт түгээмэл тархсан 10 зүйл шонхрын нэг. Тархсан нутгийнхаа орчин тогтолцоо, хүрээлэн буй орчны тэнцвэрт байдлыг хадгалахад чухал үүрэгтэй идлэг шонхрын хамгааллын бодлого нь шинжлэх ухааны үндэслэлтэй [1], [2], [3], [4] байх ёстой. Идлэг шонхрын худалдааны асуудал нь [5], [6], [7], [8], [9], [10] энэ зүйлийг монголын төдийгүй дэлхийн хэмжээний анхаарлыг татсан махчин шувууны нэг болгосныг үндэсний бахархалт шувуу [11] гэж үздэг хандлага төдийгүй популяцийн тоо хэмжээ, хамгааллын асуудал нь олон нийтэд тодорхойгүйтэй холбоотой. Тархсан нутгийн хэмжээнд 2018 онд манай орны 19 аймгийн нутаг дэвсгэрт 64,000 км<sup>2</sup> талбайг хамарсан судалгаагаар идлэг шонхрын тархац нутгийн хэмжээ 684,000 км<sup>2</sup>, голомт нутгийн хэмжээ 165,000 км<sup>2</sup> орчим байгааг тогтоов. Идлэг шонхрын үндсэн идэш тэжээл бологч цайвар үлийч (*Lasiopodomys brandtii*) зэрэг мэрэгчид, монгол болжмор (*Melanocorypha mongolica*) зэрэг тал хээрийн жижиг шувуудын тархалт нь идлэг шонхрын амьдрах орчны сонголтыг илэрхийлэгч гол хүчин зүйл болдгийг түүний үндсэн идэш тэжээл бологч зүйлүүдийн тархац нутагтай давхцуулсан шинжилгээний (Hot-Spot analysis) үр дүн харуулж байна. Аливаа зүйл шувуудын тархац нутаг, тухайлбал идлэг шонхрын амьдрах орчны нарийвчилсан мэдээлэл нь тухайн экосистемийн тэнцвэрт байдлыг илэрхийлэхээс гадна тоо толгой, нөөцийг бодитой тооцоолох шинжлэх ухааны чухал үндэслэл, хамгааллын бодлогын түлхүүр болно.

**Түлхүүр үгс:** Идлэг шонхор, идэш тэжээл, тархалт, амьдрах орчин, тоо толгой

Хүлээн авсан 2022.10.09; хянан тохиолдуулсан 2022.11.21; зөвшөөрсөн 2022.12.06

© 2022 Зохиогчид. [CC BY-NC 4.0 лиценз](https://creativecommons.org/licenses/by-nc/4.0/).

### Оршил

Дэлхийн уур амьсгалын өөрчлөлт, бүс нутгийн нийгэм эдийн засгийн эрчимтэй хөгжлийн дам шууд нөлөөгөөр биологийн олон янз байдал хомсдож,


улмаар зүйлүүд устаж үгүйрэх аюулд өртсөөр байна [12], [13], [14]. Үндсэн шалтгаан нь зүйлүүдийн амьдрах орчны доройтлоос тархац нутаг хумигдаж, идэш тэжээл хомсдож, дайжин үгүйрсэн нь зөвхөн байгалийн амьтан, ургамалд бус тэдгээрийн холбоо

хамааралд оршиж байдаг экосистем өөрчлөгдөж, түүний улмаас бүс нутгийн нийгэм эдийн засгийн хөгжил, ахуй амьдралд давхар нөлөөлж байдаг [14], [15]. Байгалийн баялгийн зүй зохистой ашиглалт, биологийн олон янз байдлын тогтвортой хамгаалал, тухайлбал экосистемд чухал үүрэгтэй зүйлүүдийн хамгааллын асуудал өнөө үед тулгамдаж байна [16]. Зэрлэг амьтдын тоо толгой, нөөцийг тогтоох нь шинжлэх ухааны болон эдийн засгийн хувьд байгалийн тэнцвэрт байдлыг хадгалах замаар ашиглалт, хамгааллыг хяналттай явуулахад [17], төдийгүй эдийн засгийн өгөөжийг зөв удирдан чиглүүлэхэд зайлшгүй шаардлагатай асуудлын нэг болсоор байна.

### Судалгааны арга зүй, хэрэглэхүүн

Судалгааг ШУА-ийн Биологийн хүрээлэнгийн Эрдмийн зөвлөлөөр баталсан “Монгол орны идлэг шонхрын тархац, тоо толгой, нөөцийн судалгаа” арга зүйн дагуу гүйцэтгэсэн. БОАЖЯ-тай байгуулсан гэрээний хүрээнд 2018 онд манай идлэг шонхор тархсан нутгийг хамарсан 25 хоногийн хугацаатайгаар нийт 40,000 км замналд 64,000 км<sup>2</sup> сорилын талбайд энэ зүйлийн үүрлэх боломжтой нийт нутгийн 30 орчим хувийг хамруулан хээрийн судалгааг гүйцэтгэв (1-р зураг).

Хээрийн судалгааг шонхрын тархцыг урьдчилан загварчилсан зураглалыг үндэслэн торлож, бүрэн хамаарахуйц хангалттай талбайнуудыг сонгосон бөгөөд Дистанс (Distance) программын шугаман болон зурвас замналын аргаар хээрийн мэдээллийг цуглуулав [18], [19]. Судалгааны замналд шувуу



1-р зураг. Идлэг шонхрын судалгааны замнал, хамарсан нутаг дэвсгэр

харагдах магадлалыг хоёр талдаа 500 метр буюу 1000 метрт тооцсон бөгөөд зурвасын өргөнийг замналын нийт урттай харьцуулж сорилын талбайн хэмжээг тооцоолсон. Зүйл тус бүрийн хувьд замналын шулуунаас 0 зайнаас эхлэн тархах перпендикуляр зайн тархалт  $f(0)$ , шувуу харагдах магадлал ( $n/L$ ), шувууны тоо  $E(s)$  зэргийг ашиглан нягтшилыг ( $D$ ) тооцоолсон. Тооцоолсон шувуудын нягтшил  $D$ -г зорилтот зүйлийн судалгааны талбайд ( $A$ ) үржүүлж нийт тоо толгой ( $N$ )-г олно.

$$\check{D} = n/a = n/2wL \text{ ба } \check{N} = A\check{D}$$

Дээрх томъёогоор амьтны нягтшилыг ажиглалтад хамрагдсан талбайн хэмжээг ( $a=2wL$ ) тухайн сорилын талбайд илэрсэн амьтны тоонд ( $n$ ) харьцуулах байдлаар илэрхийлсэн [19].

Идлэг шонхрын амьдрах орчин, тархац нутгийн талбайг ( $A$ ) 2018 болон өмнөх 2002, 2010 оны судалгааны мэдээллийг нэгтгэн боловсруулж байршил, цэгэн мэдээ, хэрэглэхүүнүүд болон хүрээлэн буй орчны суурь мэдээллүүдэд үндэслэн зүйлийн тархцын загварчлалын (SDM) Максент (MaxEnt 3.3.3: [www.biodiversityinformatics.amnh.org/open\\_source/maxent/](http://www.biodiversityinformatics.amnh.org/open_source/maxent/)) программаар [20], [21], [22] амьдрах орчныг нарийвчлан тодорхойлов. Байгалийн бүс, бүслүүрийн ангилал болон ургамлын мужлалыг [23], шувууны газарзүйн мужлалыг [24] үндэслэн сэргээж ашигласан.


Максент загварчлалд байгалийн бүс бүслүүр, ургамлын тойрог, хөрс, ургамлын хэвшил, газрын бүрхэвч (Modis 2000), ландшафт, цөлжилт, экосистем ой сан, цэвдэг г.м монгол орны байгаль хүрээлэн буй орчны суурь зургууд [25], [26], болон цасны хуримтлал, хуурайшилтын индекс, нарны тусгал, салхи, ууршилт болон амьтны уур амьсгалын (1960-2000 оны) Био-19 шүүлтүүрүүдийг Дэлхийн уур амьсгал ба цаг уурын мэдээллийн сан"-аас (WorldClim) ашигласан. Идлэг шонхрын гол идэш бологч зүйлүүдийн оролцоо, хувь, хамаарлаас [27] өндөр зүйлүүдийг эрэмбэлэн сонгон авч амьдрах орчныг нь Максент программаар загварчилж, суурь шүүлтүүр болгож ашиглав.

Загварчлалаас гарсан бүтээгдэхүүн (ASCII) файл хувилбарыг газрын зургийн ArcGIS 10.1 ашиглан боловсруулж raster төлөвт шилжүүлснээр тухайн зүйл амьтны амьдрах орчны загварчлалыг тархалтын


байдлаар нь 5 ангилж түүнээс өндөр магадлалтай (90-100%), дунд магадлалтай (70-80%), боломжит магадлалтай (50-70%) гэсэн 3 хувилбараар идлэг шонхрын амьдрах орчныг дээрх байршил, тархац нутгийн ялгаатай төлөв байдлыг 1) Голомт, 2) Тархац, 3) Дэлхэц нутаг гэж 3 байдлаар зураглаж үзүүлсэн бөгөөд тэдгээрийн талбайд үндэслэн нөөцийн тоймыг тооцоолсон болно. Идлэг шонхор болон түүний идэш тэжээл бологч хөхтөн, шувууны зүйлүүдийн голомт ба тархац нутгийн хоорондын хамаарлын статистик тооцооллыг Minitab 16.1.1 программын Pearson correlation ашиглан гүйцэтгэсэн. Идлэг шонхрын үүрлэх биетийг энэ зүйлийн судалгааны өмнөх бүх үеүдэд баримталдаг “ялган тэмдэглэх” нийтлэг 5 биетээр [27], [28] төлөөлүүлэх аргачлалыг баримталсан бөгөөд, 2018 оны судалгаанд хиймэл үүрийг нэмж 6 болгосон. Судалгааны хугацаанд цахилгааны модон болон төмөр шон, хад цохио г.м үүрлэх биет бүрийг аюулгүйн үүднээс нарийвчлан хэмжих зааварчилгаа өгөгдөөгүй тул зөвхөн тодорхой боломжит зайнаас дуран, хэрэгсэл ашиглан үүр болон үүрэн дэх ангаахай, өндгийг ялгаж, тоолсон болно.

### Судалгааны үр дүн ба хэлэлцүүлэг


Идлэг шонхрын популяцийн судалгааны тойм: Идлэг шонхрын дэлхийн популяцийг 6,100-14,900 хос (дунджаар 10,500), бие гүйцсэн бодгаль 1,200-29,800 байна [29] тооцсон байна. Энэ зүйлийн тоо толгойн байдлыг тархац нутгаар ангилснаас үзвэл Хятад (1,000-5,000 хос, дунджаар 3,000 [30], Казахстанд 2012 оны мэдээгээр 700-1,400 хос,



2-р зураг. Идлэг шонхрын (2002, 2010, 2018 он) үүрлэх орчны сонголт ба судалсан жилүүдийн харьцуулалт




3-р зураг. 2018 онд хээрийн судалгаагаар бүртгэсэн идлэг шонхрын тоо ба нутаг.



4-р зураг. Идлэг шонхрын 2002, 2018 онуудын үүрэн дахь ангаахайн тооны харьцуулалт

дунджаар 1,050 [29], Монголд 2,000-5,000 хос, дунджаар 3,500 [31], [29], болон ОХУ-д 2011 оны мэдээгээр 1,553-2,089, дунджаар 1,821 [29], [30], [31], [32], [33] гэж тооцсон мэдээ бий [27], [29], [34], [35]. Идлэг шонхрын Ази, Европын популяци 3,900-5,100 үржлийн хостой [36] гэж үзсэн нь бий. Тоо баримтыг үндэслээд, нягтшилын үнэлгээг харгалзвал Монгол оронд дэлхийн үржлийн хосын 50% орчим байгаа буюу идлэг шонхрын цөм популяци болно [27] гэжээ. Манайд идлэг шонхрыг 1996, 1997, 2002 болон 2010 онуудад хэсэгчилсэн болон үндэсний хэмжээнд БОЯ-ны захиалгаар [37], [35] тооллого судалгаануудыг зохион байгуулж байсан.

Хээрийн судалгааны хугацаанд идлэг шонхор тал хээр, ойт хээр, заримдаг говь, говийн баян бүрд, хадан цохио, хавцлууд болон өндөр хүчдэлийн ба холбооны агаарын шугам, талын овоо, шон, хуучин барилга байгууламжууд дээр үүрлэсэн байв. Нийт бүртгэсэн үүрний 33 нь хад, өндөр цохио, байцад, 36 нь өндөр хүчдэлийн шонд, 25 нь байгалийн мод болон холбооны модон шонд, 4 нь барилга байгууламж



**5-р зураг.** Монгол орны идлэг шонхрын амьдрах орчны загварчлалын үр дүн ба нөөцийн үнэлгээний суурь тархалтын үндэслэл [40]

дээр, харин 11 нь хиймэл үүрэнд байв (**2-р зураг**). Судалгаанаас үзвэл 2002 онд нийт үүрний 73 байц, хад, өндөр цохионд, 27 холбооны модон шонд, 57 өндөр хүчдэлийн шонд, 25 байгалийн модонд, харин 4 барилга байгууламж дээр зассан байсан бол, 2010 онд 97 үүр хад өндөр цохио, байцад, харин өндөр хүчдэлийн шонд 50 бүртгэгдсэн байхад 2018 оны судалгаагаар хад өндөр цохио бүхий газарт 33 үүр, холбооны модон шонд 25 үүр, өндөр хүчдэлийн шонд 36 үүр, барилга байгууламж дээр 4 үүр, хиймэл үүрэнд 11 тохиолдлыг тэмдэглэв (**2-р зураг**). Идлэг шонхрын үүрлэх орчны сонголт, нөхцөл жил бүр харилцан адилгүй байгаа нь зүйлийн идээшил нутаг тухайн байгалийн бүс, бүслүүр дахь үндсэн идэш тэжээлийн элбэгшил, нөөц болон цаг уураас хамаарч ялгаатай байгаа нь тодорхой байна.

Идлэг шонхрын ангаахайн тоо мөн адил харилцан адилгүй байгааг 2002, 2018 оны судалгааны дүнг харуулж байна (**4-р зураг**). Нийт бүртгэсэн үүрэн дахь ангаахайг ажигласнаас үзвэл, 2002 онд 22 үүрэнд 1 ангаахай, 46 үүрэнд 2 ангаахай, 69 үүрэнд 3 ангаахай, 35 үүрэнд 4 ангаахай, 14 үүрэнд 5 ангаахай тоолсон байхад, 2018 оны судалгаагаар 40 үүрэнд 1 ангаахай, 30 үүрэнд 2 ангаахай, 18 үүрэнд 3 ангаахай,

8 үүрэнд 4 ангаахай, 13 үүрэнд 5 ангаахай ажиглаж, бүртгэжээ (**4-р зураг**).

Идлэг шонхрын өндөг болон ангаахай тоо, өсөлт жил бүр адилгүй байгаа нь идээшил нутгийн уур амьсгал, хүрээлэн буй орчны нөхцөл, ялангуяа гол идэш тэжээлийн нөөцийн элбэгшилтэй шууд дам холбоотойг судлаачдын мэдээ, баримтууд [27], [28], [38] харуулж байна. Судалгаанаас үзвэл идлэг шонхрын тархалт нь үндсэн идэш тэжээл болох үлийн цагаан оготнотой давхцадаг. Ажиглалтаар 1994-1995 онд үлийн цагаан оготнын тоо толгойн ихсэлтийн жил байснаас 1995 оны зуны сүүлээр Арвайхээр Баянхонгорын хооронд 600 километр 183 шонхор, Хангайн уулсын өмнө хэсгээр 3,706 километр 822 шонхор тоолсон нь үлийн цагаан оготнын намрын ихсэлтээр шонхрын нягтшил 1км/0.2 толгой байсан бол үлийн цагаан оготнын тоо толгой толгойн уналтын үед идлэг шонхрын нягтшил 1км/0.06-0.08 болж цөөрсөн [28], оготнын тоо олшрох үед идлэгийн тэжээлд түүний эзлэх хэмжээ 67.7% хүрч нэмэгдэх ба бусад хөхтөн 15.9%, шувуу 27.6% хүрч багасна. Идлэг шонхрын идэш тэжээлд үлийн оготно мэт мэрэгчдийн эзлэх хэмжээ ихэсдэг нь зөвхөн тэдгээрийн тоо толгой, нягтшил өндөр нутагт



тохиолдоно. Өндөглөсөн шонхрын тоо олшрох нь үлийн оготнын олшрол болон цасан бүрхэвчийн нимгэрэлт, 2-5 сарын агаарын дулаарлаас шууд шалтгаална. Хосын өндөгний дундаж тоо нь үлийн цагаан оготнын нягтшилаас хамаардаг. Байгалийн ба байгалийн бус биет дээр үүрлэсэн үржлийн хосын өндөгний хорогдолд үлийн оготнын нягтшил шууд нөлөөлнө [27] гэж тэмдэглэсэн зэргээс үзвэл цайвар үлийч зэрэг үндсэн идэш тэжээл бологч зүйлүүдийн элбэгшлээс идлэг шонхрын тухайн жилийн байршил, үржил, төлжил ихээхэн хамаардгийг 2018 судалгааны дүн харуулж байна.

Нэг үүрэнд бүртгэсэн ангаахайн тоогоор Төв, Дорноговь, Хэнтий, Дорнод, Говьсүмбэр, Дорноговь аймгуудад илүү олон байгааг үндсэн идэш бологч цайвар үлийч болон бусад мэргчид, жижиг шувууд элбэг байснаар тайлбарлаж болно. Идлэг шонхрын нягтшил болон үүрний тоо 2018 оны зуны судалгаагаар Ховд, Өвөрхангай, Хэнтий, Дорноговь болон Сүхбаатар аймгийн нутаг дэвсгэрт бусдаасаа харьцангуй илүү байсан нь (3-р зураг) түүний үндсэн идэш бологч зүйлүүдийн элбэгшил сайн, харьцангуй задгай бөгөөд уудам нутагт бүртгэж илрүүлэх нөхцөл нь уул хадтай, бартаа саад ихтэй газраас давуу байснаар тайлбарлана.

Тооллого судалгааны нэгдсэн дүнгээр судалгаанд хамрагдсан аймгуудад байгалийн бүс бүслүүрийн онцлог, газар нутгийн бартаа, тэжээлийн нөөц, үүрлэх нөхцөл, ангаахайн тоо зэрэгт үзүүлэх байгаль, хүний нөлөөллөөс шалтгаалан харилцан адилгүй байна.

Өндөр уулсын тогтолцоо, хэт хуурай бүс нутгаар идлэг шонхор үүрлэх нөхцөл, тоо толгой харьцангуй цөөн, тархцын баруун хэсэгтээ, тухайлбал Баян-Өлгий, Ховд аймгууд, мөн тархцын зүүн, зүүн өмнөд хэсэгт Говь-сүмбэр, Дорноговь, Сүхбаатар, Хэнтий, Дорнодын хээрийн бүстэй харьцуулахад элбэгдүү ажиглагдав (3-р зураг). Тоо толгой, нягтшил, үүрлэх нөхцөл байдлаар судалгаанд хамрагдсан 19 аймгуудаар харьцуулбал бие гүйцсэн бодгаль 503, ангаахай 199, нийт 702 толгой шонхор бүртгэсэн бөгөөд ангаахай болон өндөгтэй үүр нийт 109 бүртгэсэн. Баруун бүсэд ангаахай, өндөгтэй үүр бүртгээгүй ч үүрнээсээ ойр нисэж буй идлэг шонхрын ангаахайнуудыг ажиглаж чадсан нь өргөргийн дагуу өндөглөх, ангаахай гарах хугацаа харилцан адилгүй байсныг тодорхой харуулав.

Идлэг шонхрын 2002, 2010, 2018 оны судалгааны хугацаанд үүрэнд бүртгэсэн ангаахайн тооны эзлэх хэмжээ нийт бодгальд 2002 онд 29.36%, 2010 онд 38.20%, 2018 онд 28.34% байна (4-р зураг). Идлэг шонхрын өндөгнөөс ангаахай гарах үеийн байгалийн хорогдол 70% хүртэл гэж судлаачид тэмдэглэсэн [39] нь залуу шувуудын мэнд үлдэлд буюу амьдрах чадвар ойролцоогоор 30% байна. Нийт хорогдлын дотор өндөгний эндэгдэл 34.5%, ангаахайнх 40.5%, бие гүйцсэн бодгалийнх 24.9% байсныг тогтоосноос үзвэл цаашид нарийвчлан судлах зайлшгүй шаардлагатай болохыг харуулна [27]. Идлэг шонхрын үүрлэх орчны сонголт нь түүний тархалтад чухал учраас судалгааны мэдээнд үндэслэн монгол орны хэмжээнд 2018 оны байдлаар идлэг шонхор үүрлэх боломжтой тархац нутгийн хэмжээ 367,000 км<sup>2</sup>, голомт нутгийн хэмжээ 65,001 км<sup>2</sup> байх (5-р зураг) үндэслэлтэйг тодруулав [40]. Манай орны нутагт идлэг шонхор төвийн буюу Дундад халхын хээрийн бүсийг илүүтэй сонгон үүрлэж байгааг цаашдын хамгааллын менежментэд анхаарах шаардлагатай.

Тархац байршил: Идлэг шонхор Монгол орны Алтай, Говийн Алтай, Хөвсгөл, Хангай, Хэнтийн уулын хээр, тал, хээржсэн цөл, говийн толгод, хад чулуутай, модгүй уулсаар түгээмэл тархсан шувуу. Энэ зүйлийн тоо толгой, нөөцийг бодитой үнэлэхэд тархсан нутгийн хэмжээ, амьдрах орчныг нарийвчлан тогтоох зайлшгүй бөгөөд хамгааллын чухал үндэслэл юм. Судалгааны хугацаанд цуглуулсан болон өмнөх судалгааны баримтуудыг үндэслэн монгол орны идлэг шонхрын амьдрах орчны загварчлалаар 2018 онд энэ зүйлийн тархац нутгийн хэмжээ 683,633,70 км<sup>2</sup>, харин голомт нутгийн 165,799,46 км<sup>2</sup> байгааг (5-р зураг) судлан тодруулав. Ховдын уулын цөлжсөн хээр, Их нууруудын хотгорын цөлөрхөг хээр, Монгол-Алтайн уулын хээр, Хангайн уулын ойт хээр, Олон нуурын хөндийн цөлөрхөг хээр, Говь-Алтай уулын цөлөрхөг хээр, Алаша говийн цөл, Монгол дагуурын уулын ойт хээр, Дундад халхын хээр, Дорноговийн цөлөрхөг хээр болон Дорнод монголын хээрийг хамарсан манай орны нийт нутаг дэвсгэрийн 46% нь идлэг шонхрын тархац нутагт, Хангайн уулын ойт хээрийн баруун хойд хэсэг, Дундад халхын хээр, Алаша говийн цөлийн зүүн өмнөд хэсэг, болон Дорноговийн цөлөрхөг хээрийн баруун өмнөд хэсгийг хамарсан голомт нутаг нь нийт


нутгийн 12% тус тус эзэлж байгааг тогтоосон нь идлэг шонхор, түүний идэш тэжээл бологчдын судалгаа, хамгааллыг шинэ түвшинд гаргах боломжтой болов.

Тархсан нутгийнхаа экосистемд чухал үүрэг, оролцоотой бүлэг амьтад бол махчин шувуу юм. Ялангуяа, идлэг шонхрын хамгааллын тодорхой арга хэмжээ нь тархсан нутагтаа идэш тэжээл бологч олон зүйл жигүүртэн, хөхтний амьдрах орчны эрүүл, тэнцвэрт байдлыг шууд дам илтгэн, тодорхойлогч байдгаас тархац нутгийн чухал байршлуудыг хамгааллын шаталбар арга хэмжээнд хамруулах нь нэн чухал байдаг. Судалгаагаар тогтоосон идлэг шонхрын тархац нутаг, амьдрах орчны 14.8% нь одоогийн УТХГН-н сүлжээнд хамрагдсан байгааг тодруулснаас үзвэл тархац нутгийн 3.2% ДЦГ-т, 4.1% БЦГ-т, 2.4% БНГ-т, 0.1% БДГ-т, 5.8% ТХГН-н орчны бүсэд, нийт 14.8%, харин голомт нутгийн 2.5% ДЦГ-т, 1.5% БЦГ-т, 1.9% БНГ-т, 3.7% нь орчны бүсэд, нийт 9.6% УТХГН-т хамрагдсан байгаа нь тал хээрийн экосистемд чухал үүрэгтэй, хүрээлэн буй орчны тэнцвэрт байдалд оролцоо өндөртэй идлэг шонхрын амьдрах орчны 85.2% хамгааллын ямар нэг шаталбар арга хэмжээнд хамрагдаагүйг анхаарах шаардлагатайг онцлов. Байгалийн олон янзын нөхцөлд тархсан идлэг шонхор хээрийн бүсэд энэ зүйлийн голомт нутгийн 37.9%, тархац нутгийн 24.6% оногдох дарааллаар хуурай хээрт 30.4%, (24.8%), цөлжүү хээрт 10%, (14.6%), ойт хээрт 8.5%, (11.8%), нугат хээрт 8.2%, (6.0%), жинхэнэ цөлд 3.5%, (5.3%), тайгад 0.9%, (1.2%), өндөр ууланд 0.4%, (2.8%), заримдаг цөлд 0.3%, (6.8%), хээржүү цөлд 0.0%, (2.0), хэт гандуу цөлд 0.0%, (0.2%) багтсан байна. Хээр, хуурай хээр, цөлжүү хээр, ойт хээр,

нугат хээрийн бүс бүслүүрт голомт, харин тархац нутаг хуурай хээр, хээр, цөлжүү хээр, ойт хээрт илүү идлэг шонхрын амьдрах орчин ногдож байна (**6-р зураг**).

Шувууны олон янз байдал, орших хэлбэр, гарал үүслийн асуудал түүний хамгаалалд нэн чухал үүрэгтэй. Төв Ази ба Сибирийн жигүүртний аймгийг газарзүйн хувьд ангилан хуваах асуудлаар хуучнаар ЗХУ-н [41], [42], [43], [44] судлаачдын бүтээлүүд чухал байр суурьтай бөгөөд манай орны умард хагасын судалгаанд үндэслэн Монгол жигүүртний аймгийн мужлалыг нарийвчилсныг баримталдаг. Гэвч тухайн орны газар нутгийн онцлог, үндэсний эрдэмтдийн судалгаанд үндэслэн боловсруулсан мужлалыг ашиглах нь зүйтэйг харгалзан үндэсний судлаачийн монгол орны шувууны газарзүйн мужлалыг зохиосныг сэргээн зураглаж, тус ангиллыг идлэг шонхрын тархцыг тэрхүү тойрог, мужид хуваарилж ялгасан [24] (**7-р зураг**).


Монгол орны шувууны газарзүйн мужлалаар [24] идлэг шонхрын тархац нутгийг ангилбал Евроазийн шилмүүст ойн тойрогт голомт нутаг 7.9%, тархац нутаг 9.9% гэсэн дарааллаар Евроазийн хээрийн тойрогт 84.4%, 56.5%, Манжуур Хятадын тойрогт 0.0%, 0.1%, Төв Азийн уулархаг цөлийн тойрогт 7.7%, 33.5% тархсан нь идлэг шонхор жинхэнэ хээрийн зүйл шувуу болох нь тодорхой байна (**7-р зураг**). Харин мужийн хувьд Монгол дагуурын мужид голомт нутаг 70.2%, тархац нутаг 45.3% гэсэн дарааллаар Орхон Сэлэнгэд 13.9%, 9.6%, Умард хангайд 7.8%, 8.7%, Өмнөд говьд 3.5%, 4.7%, Монгол алтайн уулын цөлд 1.8%, 10.7%, Нууруудын хөндийн цөлд 1.6%, 6.0%, Умард говьд 0.9%, 11.2%, Хангайн өмнөд ууланд 0.3%, 1.6%, Баруун хуурай хотгорт 0.0%, 1.2%, Хөвсгөлд 0.0%, 0.5%, Хэнтийд 0.0%, 0.4%, Баруун хянганы мужид 0.0%, 0.1% багтсан байна.



**6-р зураг.** Идлэг шонхрын (*Falco cherrug* Gray, 1834) амьдрах орчин байгалийн бүс бүслүүрт тархсан байдал

**Тархац, тоо толгой**

Судлаачдын мэдээгээр [45] Монгол улсын нутагт 2,800 гаруй үржлийн хос идлэг шонхор байдаг гэжээ. Цайвар үлийч манай орны нутаг дэвсгэрийн 40 сая орчим га талбайд тархсан байдлаас үзвэл идлэг шонхрын үндсэн тэжээл хангалттай, өргөн хүрээнд тархсаныг харуулах бөгөөд 2,800 гаруй үржлийн хос шонхор байх үндэслэлтэйг [39] тооцоолсон байдаг. Идлэг шонхрын тархац, тоо толгой нөөцийн



7-р зураг. Идлэг шонхрын (*Falco cherrug* Gray, 1834) Шувууны тойрог болон мужлалд тархсан байдал (Болд, 1989)

1-р хүснэгт. Идлэг шонхор (2018 он) ба түүний идэш тэжээл бологч зүйлүүдийн голомт нутгийн хамаарал

	Голомт	голомт_үлий	голомт_шишүүхэй	голомт_эвэрт болжмор	голомт_боролзой болжмор
голомт_үлий	0.510				
<i>P</i> -утга	0.026				
голомт_шишүүхэй	-0.245	-0.034			
<i>P</i> -утга	0.312	0.890			
голомт_эвэрт болжмор	0.752	0.122	-0.200		
<i>P</i> -утга	0.000**	0.618	0.412		
голомт_боролзой болжмор	0.655	0.442	0.028	0.744	
<i>P</i> -утга	0.002**	0.058	0.911	0.000	
голомт_монгол болжмор	0.710	0.534	0.979	0.740	0.964
<i>P</i> -утга	0.001**	0.018	0.000**	0.000**	0.000**

\*\*статистикийн хувьд ач холбогдолтой

2-р хүснэгт. Идлэг шонхор (2018 он) ба түүний идэш тэжээл бологч зүйлүүдийн дэлхэц нутгийн хамаарал

	Дэлхэц	дэлхэц_үлий	дэлхэц_шишүүхэй	дэлхэц_эвэрт болжмор	дэлхэц_боролзой болжмор
дэлхэц_үлий	0.700				
<i>P</i> -утга	0.001**				
дэлхэц_шишүүхэй	0.399	0.552			
<i>P</i> -утга	0.090	0.014			
дэлхэц_эвэрт болжмор	0.756	0.813	0.378		
<i>P</i> -утга	0.000**	0.000**	0.111		
дэлхэц_боролзой болжмор	0.433	0.658	0.786	0.551	
<i>P</i> -утга	0.064	0.002**	0.000**	0.015	
дэлхэц_монгол болжмор	0.564	0.884	0.702	0.702	0.899
<i>P</i> -утга	0.012	0.000**	0.001**	0.001**	0.000**


\*\*статистикийн хувьд ач холбогдолтой

үнэлгээний 2002, 2010, 2018 оны мэдээний дундаж ойролцоо байна [35], [39], [40]. Үндэсний хэмжээний 2018 оны тооллого судалгаагаар байгалийн бүс бүслүүрийн онцлог, ургамалжилт, зуншлага, газар нутгийн бартаа тэжээлийн нөөц, үүрлэх, ангаахайд үзүүлэх хүний нөлөөллөөс шалтгаалан тархац, тоо толгой, нөөц нь өмнөхөөс харилцан адилгүй байв. Хэт хуурай бүс нутгаар үүрлэх нөхцөл, тоо толгой харьцангуй цөөн, харин өндөр уулын хээр, дундад халхын хээрийн бүс нутагт элбэг ажиглагдав. Идлэг шонхрын судалгааны 2002, 2010 болон 2018 оны, нийт 3 жилийн судалгааны тархац, тохиолдцын мэдээллүүдийг нэгтгэснээр манай орны идлэг шонхрын тархац, амьдрах орчны загварчлалыг боловсруулснаас үзвэл монгол орны 708,226,42 км<sup>2</sup> нутаг энэ зүйлийн тархац нутаг, харин 179,608,42 км<sup>2</sup> нутгийг голомт нутагт тооцох үндэслэлтэй байна. Идлэг шонхрын тооцсон голомт нутгийн хэмжээ нь тархац нутгийн 25%-тай тэнцэж байна. Загварчлалын шинжилгээг үндэслэвэл өмнөх судалгааны жилүүдэд, тухайлбал 2002 онд тухайн жилийн идлэг шонхрын тархац нутаг 363,738,9 км<sup>2</sup>, голомт нутгийн хэмжээ 54,477,9 км<sup>2</sup>, 2010 оны тархац нутгийн хэмжээ


411,889,42 км<sup>2</sup>, голомт нутгийн хэмжээ 59,284,31 км<sup>2</sup> байсан гэх үндэслэлтэй байна.

2018 оны судалгааны мэдээгээр идлэг шонхрын тархац нутгийн хэмжээ 683,633,7 км<sup>2</sup>, голомт нутгийн хэмжээ 165,799,46 км<sup>2</sup> байгааг тогтоосон явдал нь идлэг шонхрын тархах нутаг тухайн жилийн нөхцөлөөс шалтгаалан харьцангуй ялгаатай байгааг нотолж байна. Иймээс цаашид амьдрах орчны 2002, 2010 болон 2018 онуудын нийт загварчлалын судалгааны нэгтгэсэн үр дүнд боловсруулсан идлэг шонхрын тархац нутгийн хэмжээ (708,200 км<sup>2</sup> ба 179,600 км<sup>2</sup>) хамгааллын аливаа арга хэмжээнд суурь болгон ашиглах нь зүйтэй бөгөөд тухайн онуудын тус бүрийн мэдээнүүд харьцуулах чанартай байж болно.

Идлэг шонхрын амьдрах орчныг загварчилсан 2018 оны судалгааны үр дүнг өмнөх 2002, 2010 оны тархац нутгийн мэдээтэй арга зүйн хувьд харьцуулах боломжгүй байсан тул тухайн жилийн мэдээг үндэслэн ижил аргаар загварчилж харьцуулснаас үзвэл 2002 оны идлэг шонхрын тархац (36,373,69 км<sup>2</sup>) болон голомт нутгийн (54,477,89 км<sup>2</sup>) хэмжээ 2010 оны тархац нутаг (111,321,6 км<sup>2</sup>) болон голомт нутагтай (48,150,54 км<sup>2</sup>) харьцуулахад 1.1



8-р зураг. Идлэг шонхрын үндсэн идэш тэжээл цайвар үлийч ба хөх шишүүхэйн амьдрах орчны загварчлал.



9-р зураг. Идлэг шонхрын үндсэн идэш тэжээл монгол болжмор ба шоорон эвэрт болжморын амьдрах орчны загварчлал.



дахин, харин 2018 оныхтой харьцуулахад 3 дахин тэлж, нэмэгдсэн байна. Идлэг шонхрын тархац, байршил нутагт түүний үндсэн идэш тэжээл бологч зүйлүүдийн тархац ба нөөцийн элбэгшил чухал харилцан хамааралтай [27], [28], [35], [38] байна.

Судалгаанд идлэг шонхрын үндсэн идэш бологч хөхтөн ба шувууны зүйлүүдээс төлөөлөл сонгож амьдрах орчныг загварчилснаар түүний тархац нутгийг илүү бодитой загварчлахад суурь шүүлтүүр болгон ашигласнаас гадна идэгч, идүүлэгчийн амьдрах орчны хэмжээгээр хоорондын хамаарлыг тодруулсан анхны туршлага болов (**1-2-р хүснэгт; 8-9-р зураг**). Идлэг шонхрын идэш тэжээлийн бүрэлдэхүүнд багтсан [27], [46], [47], [24] 60 орчим зүйл шувуунаас 25 зүйлийг, 21 зүйл хөхтнийг эрэмбэлж эхний 6 зүйлийг сонгож амьдрах орчныг загварчилсан. Үр дүнг идлэг шонхрын суурь шүүлтүүр болгон ашигласнаас монгол болжмор, боролзой болжмор болон эвэрт болжмор зэрэг шувуу, цайвар үлийч ба хөх шишүүхэй (**8-9-р зураг**) зэрэг жижиг мэрэгчид тархцын зураглалд ач холбогдолтой хамааралтай байсны дээр статистикийн хамаарлын индексүүд харуулж байна.

Идлэг шонхрын 2018 оны голомт ба дэлхэц нутгийн хэмжээг түүний идэш бологч зүйлүүдийн голомт ба дэлхэц нутгийн хэмжээний хамаарлыг шалгаснаас харахад эвэрт болжмор, боролзой болжмор ба монгол болжмор зэрэг шувууны зүйлүүд болон хөх шишүүхэйн тархацтай шууд хамааралтай (**1-р хүснэгт; 8-9-р зураг**) судалгаа нотолж байна. Идлэг шонхрын 2018 оны дэлхэц нутгийн хэмжээ түүний идэш тэжээл бологч зүйлүүдээс цайвар үлийч, хөх шишүүхэй зэрэг мэрэгчид болон монгол болжмор ба эвэрт болжморын тархацтай шууд хамааралтай байгаа нь (**8-9-р зураг, 2-р хүснэгт**) түүний дэлхэц нутгийн хэмжээ цайвар үлийчийн тархсан нутгийн зарим хэсэгт илүүтэй давхцаж, хамаарал илүү өндөр байгааг харуулж байна. Идэш тэжээл бологч мэрэгчдээс цайвар үлийч, шувуудаас эвэрт болжмор, боролзой болжмор, монгол болжморын амьдрах орчин нь идлэг шонхрын дэлхэц нутагтай хамааралтай ач холбогддогтойг судалгаа нотолж байна.

Идлэг шонхрын өмнөх онуудын мэдээг нэгтгэсэн амьдрах орчны талбайг түүний идэш тэжээл бологч зүйлүүдийн голомт нутгийн хамаарлыг шалгаснаас

үзвэл судалгаа хийгдсэн 3 оны голомт нутагтай эвэрт болжмор, монгол болжмор, боролзой болжмор болон хөх шишүүхэй, цайвар үлийчийн амьдрах орчин хамаарал статистикийн хувьд ач холбогдолтойг харуулсан. Судалгаагаар идлэг шонхрын тархац нутаг, амьдрах орчин нь хамрагдсан байдлаараа засаг захиргааны хилээр аймгууд харилцан адилгүй байхаас гадна голомт нутгийн хамгааллын хувьд Төв, Хэнтий, Дундговь, Өвөрхангай, Сүхбаатар болон Завхан аймгууд, харин тархац нутгийн хэмжээгээр Хэнтий, Сүхбаатар, Дорнод, Төв болон Дундговь аймгууд ач холбогдол өндөр байна.

Монгол орны хэмжээгээр 2018 оны идлэг шонхрын судалгаагаар Баян-Өлгий, Ховд аймгийн хэмжээнд тархац нутагтаа 100 км<sup>2</sup> 3 бодгаль, Увс, Завхан аймагт 100 км<sup>2</sup> 1 бодгаль, Говь-Алтай, Баянхонгор аймагт 100 км<sup>2</sup> 1 бодгаль, Хөвсгөл, Архангай аймагт 100 км<sup>2</sup> 1 бодгаль, Өвөрхангай, Өмнөговь аймагт 100 км<sup>2</sup> 1 бодгаль, Булган, Сэлэнгэ аймагт 100 км<sup>2</sup> 1 бодгаль, Төв, Дундговь аймагт 100 км<sup>2</sup> 2 бодгаль, Дорноговь, Говьсүмбэр, Сүхбаатар аймагт 100 км<sup>2</sup> 5 бодгаль, Хэнтий, Дорнод аймагт 100 км<sup>2</sup> 1 бодгаль ногдох нягтшилтайгаар манай орны 683,634 км<sup>2</sup> дэлхэц нутагтаа 100 км<sup>2</sup> дунджаар 1.5 бодгаль ногдох нягтшилтай, нийт 10,380 орчим бодгаль идлэг шонхрын нөөцтэй болохыг тогтоосон. Идлэг шонхрын тоо нөөцийг тархац нутаг, амьдрах орчны ялгаатай байдалд үндэслэн аймаг тус бүрээр тоймлон тооцоолсон ч засаг захиргааны нэгжийн хил амьтны зүйлүүдийн хувьд холбогдол багатайг харгалзсан төдийгүй тэр мэдээлэл зөвхөн байгалийн ялгаатай нөхцөлд энэ зүйлийн тархах онцлогийг тодруулахад туслах үүрэгтэй.

## Дүгнэлт

1. Монгол орны нутаг дэвсгэрийн хэмжээнд 2002, 2010 болон 2018 онд тооцоолсон идлэг шонхрын тархац нутаг, амьдрах орчны хэмжээ харилцан ялгаатай байгаа нь тухайн жилийн цаг уур, хүрээлэн буй орчин, идэш тэжээлийн нөөцөөс хамааралтай байна.
2. 2018 оны байдлаар манай орны идлэг шонхрын тархац нутгийн хэмжээ 683,634 км<sup>2</sup>, голомт нутгийн хэмжээ 165,800 км<sup>2</sup> байна. Тархац,

голомт нутгийн хэмжээ байгалийн нөхцөлөөс шалтгаалан хэлбэлзэнэ.

3. Монгол орны нийт нутаг дэвсгэрийн 46% идлэг шонхрын тархац нутагт тооцогдох бөгөөд түүний 12% нь энэ зүйлийн голомт нутагт тооцогдоно.
4. Монгол оронд судалгааг зохион явуулсан 2018 онд нийт тооцоолсон нутаг дэвсгэрийн хэмжээнд 10,380 бодгалийн нөөцтэй байна. Нийт нөөцийн 30 орчим хувийг залуу бодгаль эзэлнэ.
5. Монгол орны идлэг шонхрын амьдрах орчныг ялгаатай нарийвчилсан газрын зургийн мэдээллийг бий болгов. Цаашид энэ мэдээлэлд үндэслэн уур амьсгалын өөрчлөлтийн ирээдүйн төсөөллийг тооцоолоход хөдөлгөөнт мэдээллээр ашиглах суурьтай болов.
6. Идлэг шонхорын популяцийг тархсан нутагт нарийвчилсан судалгаа, мониторингд үндэслэн популяцид эрсдэлгүйгээр, хамгаалал, шинжилгээнд хөрөнгө оруулах зорилгоор тодорхой тоогоор тусгай зөвшөөрөл олгодог тогтолцоог нэвтрүүлэх үндэслэлтэй.
7. Тал хээрийн орчин тогтолцоонд нэн чухал үүрэгтэй махчин шувуудын үндсэн идэш тэжээл бологч мэрэгчдийн эсрэг устгалын асуудлыг тэдгээр зүйлүүдийн хамгааллын менежменттэй нягт уялдаатай, шинжлэх ухааны үндэслэлтэй хэрэгжүүлэх шаардлагатай.

## Санал, зөвлөмж

1. Идлэг шонхорын тоо нөөцийг тогтоох судалгааны ажлыг тухайн зүйл шувууны үржлийн үе тохиоц цаг хугацаанд нь багтаан хангалттай нутаг дэвсгэрт, өргөн хүрээгээр гүйцэтгэх.
2. Монгол орны идлэг шонхорын нөөцийн судалгааг 2 жил тутамд тогтмол гүйцэтгэхдээ анхаарал татсан голомт нутгуудад мониторингийн судалгааг байнга, тасралтгүй хэрэгжүүлснээр үндэсний хэмжээний судалгааны үр дүнг илүү бодитой, үр дүнтэй болгоно.
3. Идлэг шонхор төдийгүй олон зүйл махчин шувуудын үндсэн идэш тэжээл бологч амьтдын зүйлүүдийн (жижиг хөхтөн, бусад шувууд, шавжийн) тархалт, нөөцийн судалгааг цогцоор гүйцэтгүүлж байх.
4. Олширсон үедээ бэлчээрт хөнөөлтэй мэрэгчидтэй

идлэг шонхор мэт махчин шувуудаар дамжуулан нөлөөлөх, хянах шинжлэх ухааны төлөвлөлт, бодлогыг энэ чиглэлийн мэргэжлийн байгууллагууд болон байгаль хамгаалах байгууллага хоорондын уялдаа холбоо, харилцан дэмжлэгийг сайжруулах замаар хөгжүүлэх арга хэмжээг авах шаардлагатай байна.

## Талархал

“Идлэг шонхорын тоо толгой, нөөцийн судалгаа (дугаар: БОАЖЯ/201804070)”-ны ажлыг санхүүжүүлсэн МУ-н ЗГ, Байгаль орчны аялал жуулчлалын яаманд талархал илэрхийлье. Мөн үндэсний хэмжээний судалгааг гүйцэтгэхэд хувь нэмрээ оруулж, хамтран ажилласан 9 багийн гишүүд, нийт судлаачид, оюутан, орон нутгийн мэргэжилтнүүд болон жолооч нартаа ШУА-н Биологийн хүрээлэнгийн нэрийн өмнөөс гүн талархал илэрхийлье.

## Ашигласан бүтээл

- [1] J. A. Donazar *et al.*, “Roles of Raptors in a Changing World: From Flagships to Providers of Key Ecosystem Services,” *Ardeola*, vol. 63, no. 1, pp. 181–234, Jun. 2016, <https://doi.org/10.13157/arla.63.1.2016.rp8>.
- [2] E. R. Buechley *et al.*, “Global raptor research and conservation priorities: Tropical raptors fall prey to knowledge gaps,” *Divers. Distrib.*, vol. 25, no. 6, pp. 856–869, 2019, <https://doi.org/10.1111/ddi.12901>.
- [3] F. Sergio *et al.*, “Top Predators as Conservation Tools: Ecological Rationale, Assumptions, and Efficacy,” *Annu. Rev. Ecol. Evol. Syst.*, vol. 39, no. 1, pp. 1–19, 2008, <https://doi.org/10.1146/annurev.ecolsys.39.110707.173545>.
- [4] C. J. W. McClure *et al.*, “State of the world’s raptors: Distributions, threats, and conservation recommendations,” *Biol. Conserv.*, vol. 227, pp. 390–402, Nov. 2018, <https://doi.org/10.1016/j.biocon.2018.08.012>.
- [5] Е. Потапов, С. Банзрагч, and Н. Фокс, “Монгол орны идлэг шонхорын судалгаа, хамгаалал,” *Идлэг шонхор ба жороо тоодгийн ОУ-н бага хурлын эмхэтгэл*, Улаанбаатар, Монгол Улс, 2001, p. 240.
- [6] *Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенцын лавлах*. Улаанбаатар, Монгол Улс: CITES-г

хэрэгжүүлэх Монголын үндэсний зөвлөл. Монгол улсын БОЯ, Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага, 2001.

- [7] Б. Чимэддорж, С. Пүрэвсүрэн, Х. Тэрбиш, *Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенцын лавлах*. Улаанбаатар, Монгол Улс: БОАЖЯ, Монгол улсад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, 2018.
- [8] P. Zahler *et al.*, “Illegal and Unsustainable Wildlife Hunting and Trade in Mongolia,” *Mong. J. Biol. Sci.*, vol. 2, pp. 23–31, Dec. 2004, <https://doi.org/10.22353/mjbs.2004.02.14>.
- [9] “АМЬТНЫ ТУХАЙ МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ: ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА.” <https://legalinfo.mn/> (accessed Feb. 06, 2022).
- [10] “ИДЛЭГ ШОНХОР ШУВУУНЫ ЖИШИГ ҮНЭ, ТӨЛБӨР, ХУРААМЖ ТОГТООХ ТУХАЙ.” <https://legalinfo.mn/> (accessed Feb. 06, 2022).
- [11] “ҮНДЭСНИЙ БАХАРХАЛТ ШУВУУГ ЗАРЛАХ ТУХАЙ.” <https://legalinfo.mn/> (accessed Feb. 06, 2022).
- [12] Д. Дагвадорж, Л. Нацагдорж, Ж. Доржпүрэв, and Б. Намхайням, “Монгол Улс: Уур амьсгалын өөрчлөлтийн үнэлгээний илтгэл 2009,” БОАЖЯ, НҮБ-н БОХ UNEP, НҮБ-ын ХХ UNDP, 2010.
- [13] D. Dagvadorj, Z. Batjargal, and L. Natsag, “Mongolia Second Assessment Report on Climate Change (MARCC-2014),” MNEGD, Ulaanbaatar, Mongolia, 2014. [Online]. Available: <http://www.jcm-mongolia.com/wp-content/uploads/2015/11/MARCC-Final-Bk-2014-book-1st.9.17-ilovepdf-compressed.pdf>
- [14] Д. Дагвадорж, З. Батжаргал, and Л. Нацагдорж, “Монгол орны уур амьсгалын өөрчлөлтийн үнэлгээний хоёрдугаар илтгэл,” БОНХЯ, Улаанбаатар, Монгол Улс, 2014.
- [15] “Биологийн олон янз байдлын тухай конвенцын үндэсний тайлан (2015-2018),” БОАЖЯ, ДБХС-н Монгол дахь хөтөлбөрийн газар, 2019. [Online]. Available: [https://wwffasia.awsassets.panda.org/downloads/20p07\\_nbsap\\_review\\_mon.pdf](https://wwffasia.awsassets.panda.org/downloads/20p07_nbsap_review_mon.pdf)
- [16] Г. Нямдаваа, Б. Авид, Я. Адъяа, and Ч. Дугаржав, *Монгол орны байгаль орчин: Монгол орны биологийн олон янз байдал*, vol. 3. Улаанбаатар, Монгол Улс: БОЯЖЯ, ШУА, 2017.
- [17] “Биологийн олон янз байдлын үндэсний хөтөлбөр 2015-2025,” БОАЖЯ, ДБХС- (WWF) Монгол дахь хөтөлбөр, НҮБ-Н Байгаль орчны хөтөлбөр (UNEP), Даян дэлхийн байгаль хамгаалах сан (GEF), 2015.
- [18] L. Thomas *et al.*, “Distance sampling,” in *Encyclopedia of Environmetrics*, vol. 1, 2002, pp. 544–552. [Online]. Available: [https://distancesampling.org/downloads/dist\\_encyc\\_env.pdf](https://distancesampling.org/downloads/dist_encyc_env.pdf)
- [19] S. T. Buckland, S. J. Marsden, and R. E. Green, “Estimating bird abundance: making methods work,” *Bird Conserv. Int.*, vol. 18, no. S1, pp. S91–S108, Sep. 2008, <https://doi.org/10.1017/S0959270908000294>.
- [20] S. J. Phillips and M. Dudik, “Modeling of Species Distributions with Maxent: New Extensions and a Comprehensive Evaluation,” *Ecography*, vol. 31, no. 2, pp. 161–175, 2008.
- [21] S. J. Phillips, R. P. Anderson, and R. E. Schapire, “Maximum entropy modeling of species geographic distributions,” *Ecol. Model.*, vol. 190, no. 3, pp. 231–259, Jan. 2006, <https://doi.org/10.1016/j.ecolmodel.2005.03.026>.
- [22] S. J. Phillips, R. P. Anderson, M. Dudik, R. E. Schapire, and M. E. Blair, “Opening the black box: an open-source release of Maxent,” *Ecography*, vol. 40, no. 7, pp. 887–893, 2017, <https://doi.org/10.1111/ecog.03049>.
- [23] А. А. Юнатов, *Основные черты растительного покрова Монгольской Народной Республики Москва: Труды Монгольской комиссии АН СССР*. 1950.
- [24] А. Болд, “Эколого-географические основы охраны и рационального использования орнитофауны МНР,” Дисс. на соискание ученой степени докт. биол. наук, Москва, 1989.
- [25] “Гео мэдээллийн сан.” [Online]. Available: <http://www.eic.mn/geodata/geomoose.html>
- [26] “Global climate and weather data — WorldClim.” <https://worldclim.org/data/index.html> (accessed Feb. 07, 2022).
- [27] С. Гомбобаатар, *Монгол орны идлэг шонхор (Falco cherrig)*. Улаанбаатар, Монгол Улс: МУИС, Монголын шувуу судлалын нийгэмлэг, 2013.
- [28] А. Болд and Ш. Болдбаатар, “Монголын идлэг шонхрын тархац, улирлын шилжилт, тоо толгойн өсөлт ба бууралт,” *Академич А.Болдын бүтээлийн эмхэтгэл*, Дэд боть (1996-2007), Улаанбаатар, Монгол Улс: ШУА, ЕБСБХ-ийн Амьтан судлалын салбар, Шувуу судлалын лаборатори, 2016, pp. 168–171.
- [29] A. Kovács, N. Williams, and C. Galbraith, *Saker Falcon Falco cherrug Global Action Plan (SakerGAP)*. 2014. <https://doi.org/10.13140/RG.2.2.19329.33123>.
- [30] A. Dixon, “Conservation of the Saker Falcon Falco cherrug and the use of hybrids for falconry,” *Aquila*, vol. 119, pp. 9–19, Jan. 2012.
- [31] A. Dixon, “Saker Falcon breeding population estimates.

- Part 2: Asia,” *Falco*, vol. 29, Jan. 2009.
- [32] I. Karyakin, E. Nikolenko, and E. Shnayder, “Results of Monitoring of the Saker Falcon Population in the Altai-Sayan Region in 2014, Russia,” *Raptors Conserv.*, pp. 58–76, Dec. 2014, <https://doi.org/10.19074/1814-8654-2014-29-58-7>.
- [33] I. V. Karyakin *et al.*, “The latest data on the distribution of the Saker Falcon in Russia and Kazakhstan,” 2012. <http://rrcn.ru/en/archives/13822> (accessed Feb. 06, 2022).
- [34] G. Haines, *An assessment of the impact of trade on the Saker Falcon*. 2002.
- [35] “Монгол орны идлэг шонхрыг (*Falco cherrug*) 2010 онд тоолсон ажлын тайлан,” ШУА, Биологийн хүрээлэн, Улаанбаатар, Монгол Улс, 2010.
- [36] E. Potapov, “Saker falcon (*Falco cherrug*) population estimates: Report of the Conservation of the Saker Falcon *Falco cherrug* and the role CITES in UAE,” 2002.
- [37] “Байгаль орчны төлөв байдлын тайлан,” Улаанбаатар, Монгол Улс, 2002.
- [38] А. Болд, Н. Цэвээнмядаг, Ш. Болдбаатар, and Г. Майнжаргал, “Результаты все Монгольского учёта сокола-балобана на территории Монголии,” *Академич А.Болдын бүтээлийн эмхэтгэл*, Дэд боть (1996-2007), Улаанбаатар, Монгол Улс: ШУА, ЕБСБХ-ийн Амьтан судлалын салбар, Шувуу судлалын лаборатори, 2016, pp. 245–250.
- [39] “Монгол орны идлэг шонхрыг (*Falco cherrug*) 2002 онд тоолсон ажлын тайлан,” ШУА, Биологийн хүрээлэн, БОЯ, Улаанбаатар, Монгол Улс, 2002.
- [40] “Монгол орны идлэг шонхрыг (*Falco cherrug*) 2018 онд тоолсон ажлын тайлан,” ШУА, Биологийн хүрээлэн, БОАЖЯ, Улаанбаатар, Монгол Улс, 2018.
- [41] П. П. Сушкин, *Список и распространение птиц Русского Алтая и ближайших частей северо-западной Монголии с описанием новых или малоизвестных форм*. Ленинград, 1925.
- [42] П. П. Сушкин, *Список и распределение птиц Русского Алтая и ближайших частей северо-западной Монголии с описанием новых или малоизвестных форм*, vol. 1/2. Бюл. МОИП. Нов. Серия. Отд. Биол. Т.41. Вып, 1932.
- [43] П. П. Сушкин, *Птицы советского Алтая и прилегающих частей северо-западной Монголии*, vol. 2. М-Л: Издательство Академии НАУК СССР, 1938.
- [44] А. Я. Тугаринов, *Северная Монголия и птицы этой страны (Отчет зоологической экспедиции в северную Монголию за 1929 г.)*. Л. Изд-во АН СССР, 1929.
- [45] О. Шагдарсүрэн, С. Гомбобаатар, Д. Сумъяа, Е. Потапов, and Н. Фокс, “Монгол орны идлэг шонхор, тоо толгой, тархалт. Монгол орны идлэг шонхрын судалгаа, хамгаалал,” in *Идлэг шонхор ба жороо тоодгийн Олон улсын бага хурлын эмхэтгэл*, Улаанбаатар, Монгол Улс, 2001, pp. 25–33.
- [46] Г. Майнжаргал, “Монгол орны богширгын овгийн шувуудын (Alaudidae) биологи, экологи, хамгаалал,” Биологийн ухааны доктор Ph.D зэрэг горилсон бүтээл, МУИС, Улаанбаатар, Монгол Улс, 2014.
- [47] Г. Майнжаргал & Д. Энхбилэг, “Тал хээрийн шувуудын хамгаалалд түймрийн холбогдол,” *Биологийн Хүрээлэнгийн Эрдэм Шинжилгээний Бүтээл*, vol. 36, pp. 118–130, 2020.